

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын мэдээллийн хуудас 2019 оны 3 дугаар сарын дугаар

Тэргүүн мэдээ

Газар хөдлөлтийг биеэр мэдрэх төхөөрөмж ашиглаж гамшгаас хамгаалах мэдлэгийг дээшлүүлнэ.



ТХА “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд газар хөдлөлтийг биеэр мэдрэх төхөөрөмжийг Улаанбаатар хотын иргэдийг гамшгаас хамгаалах сургалт арга зүйн төвд суурилуулж 3 дугаар сарын 20-ны өдөр хүлээлгэн өгөх ёслол болов. Ёслолын арга хэмжээнд МУ-ын Шадар сайд Ө.Энхтүвшин, Япон Улсын элчин сайд М.Такаока болон албаны бусад хүмүүс оролцож, газар хөдлөлтийн төхөөрөмжийг туршиж үзлээ. Монгол Улсад газар хөдлөлтийн хэд хэдэн идэвхтэй хагарлын бүс байдаг бөгөөд тэдгээр нь газар хөдлөлтийн эрсдэлтэй бүсэд ордог. Энэхүү төхөөрөмжийг ашиглан иргэдийн гамшгаас хамгаалах мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхийн зэргэцээ гамшигт урьдчилан бэлтгэх ухамсрыг илүү олон иргэдэд олгохыг зорин ажиллаж байна.

Төслийн хэрэгжилт

Тайланд улсад “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоо”-ны талаар танилцах аялал зохион байгуулав.



2 дугаар сарын 13-ны өдрөөс 21-ний өдрүүдэд ТХА “Улаанбаатар хот дахь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих төсөл (DPUB)”-ийн хүрээнд төр захиргааны байгууллагын ажилтан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл болох 8 хүн танилцах аялалаар Тайланд улсад зочлон тус улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар авч хэрэгжүүлдэг бодлого, соён гэгээрүүлэх арга хэмжээний туршлагаас суралцав. Тайландад ААН, байгууллага дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо хуулиар тогтоосон 1 хувьд хүрэхгүй тохиолдолд зөрүүг нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 1 жилийн дүнтэй дүйцэх төлбөрөөр улсад нөхөн төлөх шаардлагатай байдаг тул хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж байгаа юм. Танилцах аялалд оролцогчид энэхүү бодитой үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлэхэд төр захиргааны байгууллага ба хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагын гүйцэтгэх үүргийн талаар ойлголттой болов.

“Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дугаар шат хэрэгжиж эхлэлээ.



3 дугаар сараас ТХА “Хөрөнгийн зах зээлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн 2 дугаар шат хэрэгжиж эхлэлээ. Энэхүү төсөл нь 3 жилийн хугацаатай хэрэгжих бөгөөд төслийн хүрээнд компанийн бондод итгэх итгэл, ойлголтыг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, зохицуулалтын механизмыг бий болгох зэрэг зорилтыг тавьж буй юм. 3 дугаар сарын 11-ний өдрөөс 16-ны өдрүүдэд Япон (JCR) болон Туркийн (JCR-ER) Зэрэглэл Тогтоох Байгууллагуудын төлөөлөл Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ) болон Засгийн газрын холбогдох байгууллагууд, арилжааны банк, ББСБ, даатгалын компаниудтай уулзалт хийж, Монголын зээлжих зэрэглэл тогтоох өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагатай танилцахын сацуу цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэлэлцэв.

Монгол бяслагны чанарыг сайжруулах чиглэлээр зохион байгуулагдсан 2018 оны залуучуудын сургалтанд оролцогчид тайлангаа тавив.



Залуучуудад зориулсан “Бүс нутгийн ЖДҮ-ийг дэмжих сургалт”-д оролцогчид 3 дугаар сарын 4-ний өдөр оролцсон сургалтынхаа үр дүнгийн талаар тайлан тавив. Монголын бяслаг үйлдвэрлэгч ААН-үүдийн технологич, ЖДҮ хариуцсан төрийн албан хаагч нарын 12 хүн оролцсон энэхүү сургалт нь 2 дугаар сарын 12-ны өдрөөс 2 дугаар сарын 28-ны өдрүүдэд Япон Улсын Обихиро хотноо зохион байгуулагдсан юм. Сургалтанд оролцогчид Обихирод сурсан бяслаг хийх арга болон нутгийн бренд бий болгоход чиглэсэн тогтолцоог Монголд бодитойгоор бүрдүүлэхээс гадна хэрэглэгчдийн эрэлтийг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэх замаар энэхүү салбарыг цаашид хөгжүүлэх эрмэлзэлтэй байгаагаа илэрхийлж байв.

“Анхан ба хоёр дах, шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл”-ийн Хамтарсан Зохицуулах Хорооны хурал болов.



3 дугаар сарын 7-ны өдөр ТХА “Анхан ба хоёр дах шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараахь сургалтыг сайжруулах төсөл”-ийн 5 дахь удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хурал зохион байгуулагдлаа. Хамтарсан зохицуулах хорооны хуралд хорооны гишүүдээс гадна Японы Олон улсын эрүүл мэндийн судалгааны төвийн (ТӨААН) албаны хүмүүс оролцсон бөгөөд төслийн үйл ажиллагааны хэрэгжилтийн явцтай танилцаж, төслийн цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар хэлэлцэв. Өнөөг хүртэл төслийн хүрээнд Орхон аймгийн нэгдсэн эмнэлгийг загвар эмнэлэг болгож, Ерөнхий мэргэшил судлалын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэн дэмжлэг үзүүлж ирсэн бөгөөд төслийн үлдсэн 1 жилийн хугацаанд Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн Нэгдсэн эмнэлгийг мөн загвар эмнэлэгт хамруулах, сувिलाхуйн салбарын үйл ажиллагааг нэмж оруулах зэрэг төслийн нэмэлт үйл ажиллагааны талаар харилцан тохиролцож, эмнэлгийн мэргэжилтнийг чадавхижуулахад хамтран ажиллахаар төлөвлөж байна.

“Маружо ХК”-ний бэхэлгээний М-01 төхөөрөмжийн туршилт явагдаж байна.



Японы ЖДҮ эрхлэгчдийн бизнесийг гадаадад өргөжүүлэхийг дэмжих хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж буй “Төмөр замын тахир хэсэгт бетон дэрний бэхэлгээг нэвтрүүлэх, турших төсөл”-ийн хүрээнд 2018 оны 5 дугаар сард Японы Маружо ХК-ний үйлдвэрлэсэн бэхэлгээний М-01 төхөөрөмжийг Улаанбаатар төмөр замын 1 км орчим гол шугамын тахир хэсэгт суурилуулан, туршиж байна. Энэхүү төхөөрөмжийг суурилуулснаар төмөр замын царигийн өргөний өөрчлөлт үүсэхгүй, эдэлгээ урт, засвар арчлалтын зардлыг бууруулахаас гадна төмөр замын аюулгүй байдлыг хангахад хувь нэмэр оруулна гэж үзэж байгаа юм. 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр болсон газар дээрх хэмжилт шалгалтын үр дүнгийн тайлангийн хурал дээр галт тэрэг өнгөрөх үеийн зам төмрийн стресс нь дээрх төхөөрөмжийн ачаалал даах хүрээний дотор байгаа бөгөөд замын тахир хэсгүүдэд аюулгүй ашиглах боломжтой болохыг тэмдэглэсэн байна. Цаашид царигийн мэдээллийг тогтмол хугацаанд авч, дүн шинжилгээ хийн уг төхөөрөмжийн үр нөлөөтэй байдлыг улам бататган шалгах ажлыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөж байна.

ЖАЙКА-гийн сайн дурын үйл ажиллагаа

Байгалийн ухааны хичээл дээр хийж болох туршилтуудыг танилцуулсан цахим хуудас нээгдлээ.



ЖАЙКА-ийн сайн дурын гишүүн Яги Шинтаро, Фүкүшима Мики нар хамтран ажилладаг багш нартайгаа нийлээд гарын авлага болгон боловсруулсан Байгалийн ухааны хичээлийн туршилтуудын мэдээллээ цахим хуудсанд нэгтгэн гаргалаа. (Багш нар хаанаас ч хэдийд ч энэхүү цахим хуудсанд хандаж, мэдээлэл авах боломжтой.) Одоогийн байдлаар уг цахим хуудсанд байгалийн ухааны туршилтын хичээлийн талаарх мэдээлэл голлон тавигдаж байгаа ч цаашид бусад сайн дурын гишүүд Монгол багш нартай хамтран боловсруулсан математик, дуу хөгжим, биеийн тамир зэрэг хичээлийн болон сургуулийн өмнөх боловсролын талаарх материалыг шинээр оруулж, цахим хуудасны агуулгыг улам бүр баяжуулахаар төлөвлөж байна.

Бусад сайн дурын үйл ажиллагаа

- ЖАЙКА-ийн сайн дурын гишүүний үйл ажиллагааны тухай блог: Сайн дурын гишүүн Абэ Ёшими (2018 оны 1-р ээлж, Дуу хөгжим, Сэлэнгэ аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар)
- 3 сарын 25-ны өдөр ЖАЙКА-ийн богино хугацааны сайн дурын 1 гишүүн томилогдон ирэв. Ооүчи Юүки (2018 оны 9-р ээлж, Мал эмнэлэг/Эрүүл ахуй, ХААИС-ийн Мал эмнэлгийн сургууль)



ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбоо

ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбооны бүх гишүүдийн хурал боллоо. Холбооны тэргүүнээр Ц.Оюунбаатар улиран сонгогдлоо.



3 дугаар сарын 13-ны өдөр ЖАЙКА-ийн Сургалт Төгсөгчдийн Холбооны бүх гишүүдийн хурал хуралдаж, холбооны гишүүд болон ЖАЙКА-ийн холбогдох албан тушаалтан нийт 69 хүн оролцлоо. Хурлын үеэр өнгөрсөн жилийн үйл ажиллагааны тайлан болон ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулахын зэрэгцээ Япон дахь сургалтын үр дүнг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр идэвхитэй үйл ажиллагаа явуулсан холбооны гишүүн Ч.Жаргал (Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институтийн арга зүйч), С.Чулуунцэцэг (Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн багш) нарыг “Шилдэг туршлага нэвтрүүлэгч”-ээр шалгаруулан өргөмжлөл гардууллаа. Мөн холбооны удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгууль болж удирдах зөвлөлийн 9, хяналтын зөвлөлийн 3 гишүүнийг тус тус сонгож, холбооны тэргүүнээр Ц.Оюунбаатарыг улираан сонгов.

Бие даасан захиргааны хуулийн этгээд Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА)
Монгол дахь Төлөөлөгчийн Газар.
Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс
(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)
Утас: +976-325939, 311329, Факс: +976-310845 / E-mail: mg_oso_rep@jica.go.jp
Web: www.jica.go.jp/mongolia/index.html / FB: [JICA Mongolia](https://www.facebook.com/JICA.Mongolia)